



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

# **ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 2017 ОНД**

Улаанбаатар хот  
2018 он

**Танилцуулгыг хянасан:**

ҮСХ-ны дарга А.Ариунзаяа

ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газрын дарга Э.Эрдэнэсан

**Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:**

ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газрын Эдийн засгийн статистикийн албаны  
ахлах шинжээч Ч.Мөнхтуул

Хаяг: Засгийн газрын III байр, Улаанбаатар-20а, Монгол Улс

Утас: 11-326414, 51-261565, 1900-1212

Имэйл: [information@nso.mn](mailto:information@nso.mn), Веб хаяг: [www.nso.mn](http://www.nso.mn), [www.1212.mn](http://www.1212.mn).

## АГУУЛГА

|                                                                         |    |
|-------------------------------------------------------------------------|----|
| Нэг. Оршил .....                                                        | 4  |
| Хоёр. Хүнсний хангамжийн статистикийн үзүүлэлт .....                    | 4  |
| Гурав. Хүнсний хүртээмжийн статистикийн үзүүлэлт .....                  | 7  |
| Дөрөв. Хүнсний илчлэг шим тэжээл .....                                  | 10 |
| Тав. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд .. | 12 |

## Товчилсон үгийн жагсаалт

|         |                                                    |
|---------|----------------------------------------------------|
| ААНБ    | Аж ахуйн нэгж, байгууллага                         |
| ГЕГ     | Гаалийн ерөнхий газар                              |
| ДНБ     | Дотоодын нийт бүтээгдэхүүн                         |
| МУЗГ    | Монгол Улсын Засгийн газар                         |
| МХЕГ    | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар                  |
| НҮБ     | Нэгдсэн үндэстний байгууллага                      |
| ӨНЭЗС   | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа              |
| СХЗГ    | Стандартчилал, хэмжил зүйн газар                   |
| ҮСХ     | Үндэсний статистикийн хороо                        |
| ҮАБЗ    | Үндэсний аюулгүй байдлын зөвлөл                    |
| ҮСХ     | Үндэсний статистикийн хороо                        |
| ҮТХ     | Үндэсний тооцооны хэлтэс                           |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам         |
| ЭМЯ     | Эрүүл мэндийн яам                                  |
| ЭЦАБШХТ | Эгзэгтэй цэгийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоо |

## ОРШИЛ

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль нь манай улс хүнсний аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн зохицуулалтын шинэ орчин бий болж, уг үзэл баримтлал болон хуульд хүнсний аюулгүй байдлын тухай ойлголт, тодорхойлолтыг тодорхой тусгаж өгсөн.

Иймд батлагдсан хууль, үзэл баримтлалд нийцүүлэн хүнсний аюулгүй байдлын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог сайжруулах, тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулах, статистикийн зарим үзүүлэлтийн эх үүсвэрт дүн шинжилгээ хийх, хэрэглэгчдэд тархаах шаардлага гарч энэхүү аргачлалд нэмэлт өөрчлөлтийг тусгаж, батлуулж, мөрдөхөөр 2013 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанаас хүнсний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж ҮСХ-ны даргын 2015 оны А/12 тоот тушаалаар энэхүү аргачлалыг шинэчлэн баталсан.

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар шинэчлэн батлагдсан аргачлалын дагуу хүнсний аюулгүй байдлын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрэн бий болгож, хүнсний аюулгүй байдлын түвшинг бодитоор тогтоож, тодорхойлж байгаа нь нийгмийн эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого чиглэлийг боловсруулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай статистикийн тоо баримтыг бүрдүүлсэн болно.

Монгол улсын хүнсний аюулгүй байдал, хангамж, хүртээмж, хэрэглээ болон тогтвортой байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү эмхэтгэл судалгааны материал, суурь мэдээлэл болно гэдэгт итгэж байна.

Хүнсний аюулгүй байдал, хангамжийн статистикийн үзүүлэлтийг хүнсний хангамж; хүнсний хүртээмж; хүнсний илчлэг, шим тэжээл; хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн дөрвөн хэсэгт хуваан авч үзэв.

## НЭГ. ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүнсний хангамжийг улсын хэмжээнд тухайн хүнсний бүтээгдэхүүний жилийн нийт нөөцийг жишсэн хүн амын хүнсний жилийн хэрэгцээнд харьцуулснаар тодорхойлогдоно.

Хүнсний хангамжийн статистикийн үзүүлэлтийг тооцохдоо ЭМЯ-ны Хоол судлалын төвөөс тогтоосон дараах 13 гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг хамруулав. Үүнд: мах, махан бүтээгдэхүүн; сүү; сүүн бүтээгдэхүүн; гурил; гурилан бүтээгдэхүүн; төрөл бүрийн будаа; саахар, чихрийн зүйл; төмс; хүнсний ногоо; буурцагт ургамал; жимс, жимсгэнэ; өндөг; хүнсний тос зэрэг бүтээгдэхүүн болно.

### 1. Жишсэн хүн ам

Монгол Улсын жилийн эцсийн суурин хүн амын тоо 2017 онд 3177.9 мянга, жишсэн хүн амын тоо 2569.2 мянга болж, суурин хүн амын тоо өмнөх оныхоос 58.0 мянган хүн буюу 1.9 хувиар, жишсэн хүн амын тоо өмнөх оныхоос 45.6 мянган хүн буюу 1.8 хувиар тус тус өссөн байна.

#### Хүснэгт 1. ХҮН АМЫН ТОО

|                      | 2014       | 2015    | 2016    | 2017    | Өсөлт/бууралт |       |
|----------------------|------------|---------|---------|---------|---------------|-------|
|                      | мянган хүн |         |         |         | зөрүү         | хувь  |
| Суурин хүн амын тоо  | 2 937.9    | 3 057.8 | 3 119.9 | 3 177.9 | 58.0          | 101.9 |
| Жишсэн хүн амын тоо* | 2 392.9    | 2 476.7 | 2 523.6 | 2 569.2 | 45.6          | 101.8 |

\* ҮСХ-ын тооцоолол

**2. Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ.** Манай улсын хүн амын хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний зохистой хэрэглээг 2017 оны байдлаар тооцож үзвэл, улсын хэмжээнд жилд нийтдээ 178.2 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 150.0 мянган тонн сүү, 168.8 мянган тонн сүүн бүтээгдэхүүн, 93.8 мянган тонн гурил, 168.8 мянган тонн гурилан бүтээгдэхүүн, 46.9 мянган тонн будаа, 30.9 мянган тонн саахар, чихрийн зүйл, 112.5 мянган тонн төмс, 243.8 мянган тонн хүнсний ногоо, 37.5 мянган тонн буурцагт ургамал, 187.6 мянган тонн жимс, жимсгэнэ, 18.8 мянган тонн өндөг, 21.6 мянган тонн хүнсний тос, 9.4 мянган тонн цөцгийн тосны хэрэгцээтэй байна (Хүснэгт 2).

Жишсэн хүн амын хүнсний бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ өмнөх оныхоос 0.3-4.3 мян.тонноор нэмэгдсэн байна. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мах, махан бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ 3.2-4.3 мян.тонноор нэмэгдсэн нь хамгийн өндөр өсөлттэй байна.

## Хүснэгт 2. ЖИШСЭН ХҮН АМЫН ЖИЛИЙН ХҮНСНИЙ ХЭРЭГЦЭЭ

| Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл | Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ* | Жишсэн хүн амын хүнсний хэрэгцээ |       |       |       |
|----------------------------------|-------------------------------------------|----------------------------------|-------|-------|-------|
|                                  |                                           | 2014                             | 2015  | 2016  | 2017  |
|                                  | килограмм                                 | мянган тонн                      |       |       |       |
| Мах, махан бүтээгдэхүүн          | 69.4                                      | 165.9                            | 171.8 | 175.0 | 178.2 |
| Сүү                              | 58.4                                      | 139.7                            | 144.6 | 147.4 | 150.0 |
| Сүүн бүтээгдэхүүн                | 65.7                                      | 157.2                            | 162.7 | 165.8 | 168.8 |
| Гурил                            | 36.5                                      | 87.3                             | 90.4  | 92.1  | 93.8  |
| Гурилан бүтээгдэхүүн             | 65.7                                      | 157.2                            | 162.7 | 165.8 | 168.8 |
| Төрөл бүрийн будаа               | 18.3                                      | 43.7                             | 45.2  | 46.1  | 46.9  |
| Саахар, чихрийн зүйл             | 12.0                                      | 28.8                             | 29.8  | 30.4  | 30.9  |
| Төмс                             | 43.8                                      | 104.8                            | 108.5 | 110.5 | 112.5 |
| Хүнсний ногоо                    | 94.9                                      | 227.1                            | 235.0 | 239.5 | 243.8 |
| Жимс, жимсгэнэ                   | 73.0                                      | 174.7                            | 180.8 | 184.2 | 187.6 |
| Буурцагт ургамал                 | 14.6                                      | 34.9                             | 36.2  | 36.8  | 37.5  |
| Өндөг                            | 7.3                                       | 17.5                             | 18.1  | 18.4  | 18.8  |
| Хүнсний тос                      | 8.4                                       | 20.1                             | 20.8  | 21.2  | 21.6  |
| Цөцгийн тос                      | 3.7                                       | 8.7                              | 9.0   | 9.2   | 9.4   |

Эх үүсвэр: ЭМЯ

**3. Хэрэглээ.** Хүн амын хэрэгцээнд 2017 онд улсын хэмжээнд 364.2 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 223.0 мянган тонн гурил, гурилан бүтээгдэхүүн, 122.2 мянган тонн төмс, 129.5 мянган тонн хүнсний ногоо нийлүүлсэн байна.

## Хүснэгт 3. ХЭРЭГЛЭЭ, БИЕТ ХЭМЖЭЭГЭЭР

| Гол нэр төрөл               | Хэрэглээ    |       | Дотоодын үйлдвэрлэл |       | Цэвэр импорт |       |
|-----------------------------|-------------|-------|---------------------|-------|--------------|-------|
|                             | 2016        | 2017* | 2016                | 2017* | 2016         | 2017* |
|                             | мянган тонн |       |                     |       |              |       |
| Мах, махан бүтээгдэхүүн     | 346.6       | 364.2 | 342.6               | 378.6 | 4.0          | -14.4 |
| Гурил, гурилан бүтээгдэхүүн | 255.5       | 223.0 | 209.7               | 208.5 | 45.8         | 14.5  |
| Төмс                        | 166.0       | 122.2 | 165.3               | 121.8 | 0.7          | 0.4   |
| Хүнсний ногоо               | 149.9       | 129.5 | 94.4                | 82.1  | 55.5         | 47.4  |

Эх үүсвэр: ҮСХ, ГЕГ

\* Урьдчилсан гүйцэтгэл

**4. Хүнсний хангамжийн түвшин.** Хүнсний хангамжийн түвшинг өмнөх оныхтой харьцуулвал, мах, махан бүтээгдэхүүний хангамжийн түвшин 6.3 пунктээр өсөж, гурил, гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногооны хангамжийн түвшин 9.5-41.6 пунктээр буурсан байна.

#### Хүснэгт 4. ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН ТҮВШИН, ХУВИАР

| Гол нэр төрөл               | Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ |       | Хэрэглээ |       | Хангамжийн түвшин |       |
|-----------------------------|-----------------------------------------|-------|----------|-------|-------------------|-------|
|                             | 2016                                    | 2017  | 2016     | 2017  | 2016              | 2017  |
|                             | мянган тонн                             |       |          |       | хувь              |       |
| Мах, махан бүтээгдэхүүн     | 175.0                                   | 178.2 | 346.6    | 364.2 | 198.1             | 204.4 |
| Гурил, гурилан бүтээгдэхүүн | 257.9                                   | 262.6 | 255.5    | 223.0 | 99.1              | 84.9  |
| Төмс                        | 110.5                                   | 112.5 | 166.0    | 122.2 | 150.2             | 108.6 |
| Хүнсний ногоо               | 239.5                                   | 243.8 | 149.9    | 129.5 | 62.6              | 53.1  |

Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, махан бүтээгдэхүүнээр бүрэн хангаж, гурил, гурилан бүтээгдэхүүнээр 93.5 хувь, төмсөөр 99.7 хувь, хүнсний ногоогоор 63.4 хувь хангаж байна.

#### Хүснэгт 5. ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН ХУВЬ, ЭХ ҮҮСВЭРЭЭР, 2017 ОН

| Гол нэр төрөл                  | Хэрэглээ |                        |        | Хангамж                |        |
|--------------------------------|----------|------------------------|--------|------------------------|--------|
|                                | Хэрэглээ | Дотоодын<br>үйлдвэрлэл | Импорт | Дотоодын<br>үйлдвэрлэл | Импорт |
|                                |          |                        |        | хувь                   |        |
| Мах, махан<br>бүтээгдэхүүн     | 364.2    | 378.6                  | -14.4  | 104.0                  | -      |
| Гурил, гурилан<br>бүтээгдэхүүн | 223.0    | 208.5                  | 14.5   | 93.5                   | 6.5    |
| Төмс                           | 122.2    | 121.8                  | 0.4    | 99.7                   | 0.3    |
| Хүнсний ногоо                  | 129.5    | 82.1                   | 47.4   | 63.4                   | 36.6   |

#### ХОЁР. ХҮНСНИЙ ХҮРТЭЭМЖИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүнсний хангамж нь өрхийн түвшинд хангагдсан эсэхийг өрхийн хүнсний хүртээмжээр тодорхойлдог. Өрхийн хүнсний хүртээмжийг сэрүүний болон зуны улирлаар, хот, хөдөөгөөр тооцов.

##### 1. Жишсэн нэг хүний хүнсний бодит хэрэглээ

ӨНЭЗС-аар жишсэн нэг хүний хүнсний бодит улсын дундаж хэрэглээг авч үзэхэд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, ургамлын тосыг улсын дунджаас давж хэрэглэдэг бол хотод гурилан бүтээгдэхүүн, саахар, чихрийн зүйл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, буурцагт ургамал, өндөг, цөцгийн тосыг улсын дунджаас давж хэрэглэж байна.



**Хүснэгт 6. ЖИШСЭН НЭГ ХҮНД ХОНОГТ НОГДОХ ХҮНСНИЙ  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛСЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2017  
ОН**

| Хүнсний бүтээгдэхүүний нэр<br>төрөл | Улсын<br>дундаж | Хот        | Хөдөө      |
|-------------------------------------|-----------------|------------|------------|
|                                     | грамм           |            |            |
| Мах, махан бүтээгдэхүүн             | 309.6           | 262.5      | 408.5      |
| Сүү                                 | 173.1           | 141.8      | 238.9      |
| Сүүн бүтээгдэхүүн                   | 245.5           | 136.5      | 380.9      |
| Гурил                               | 179.7           | 125.3      | 294.0      |
| Гурилан бүтээгдэхүүн                | 175.2           | 204.2      | 114.1      |
| Төрөл бүрийн будаа                  | 62.1            | 58.5       | 69.7       |
| Саахар, чихрийн зүйл                | 55.9            | 59.3       | 48.7       |
| Төмс                                | 94.8            | 100.4      | 82.9       |
| Хүнсний ногоо                       | 74.4            | 84.2       | 54.0       |
| Жимс, жимсгэнэ                      | 33.8            | 38.7       | 23.5       |
| Буурцагт ургамал                    | 0.1             | 0.2        | 0.0        |
| Өндөг                               | 9.7             | 13.3       | 2.1        |
| Ургамлын тос                        | 16.9            | 13.7       | 20.9       |
| <b>Цөцгийн тос, масло</b>           | <b>6.6</b>      | <b>9.3</b> | <b>3.3</b> |

Эх үүсвэр: ӨНЭЗС, УСХ

ӨНЭЗС-ны жишсэн нэг хүний хүнсний бодит хэрэглээ сэрүүний улиралд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будааг улсын дунджаас давж хэрэглэдэг бол хотод гурилан бүтээгдэхүүн, саахар, чихрийн зүйл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, буурцагт ургамал, өндөг, цөцгийн тосыг улсын дунджаас давж хэрэглэдэг гэсэн үр дүн гарсан байна.

**Хүснэгт 7. ЖИШСЭН НЭГ ХҮНД ХОНОГТ НОГДОХ ХҮНСНИЙ  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛСЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ, СЭРҮҮНИЙ УЛИРАЛД, ХОТ,  
ХӨДӨӨГӨӨР, 2017 ОН**

| Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл | Улсын<br>дундаж | Хот        | Хөдөө      |
|----------------------------------|-----------------|------------|------------|
|                                  | грамм           |            |            |
| Мах, махан бүтээгдэхүүн          | 307.2           | 267.7      | 388.4      |
| Сүү                              | 161.8           | 138.5      | 209.8      |
| Сүүн бүтээгдэхүүн                | 204.6           | 127.2      | 364.0      |
| Гурил                            | 181.0           | 128.6      | 288.9      |
| Гурилан бүтээгдэхүүн             | 170.6           | 200.9      | 108.3      |
| Төрөл бүрийн будаа               | 61.1            | 58.3       | 67.0       |
| Саахар, чихрийн зүйл             | 51.9            | 52.6       | 50.5       |
| Төмс                             | 94.8            | 100.9      | 82.1       |
| Хүнсний ногоо                    | 74.4            | 83.9       | 54.8       |
| Жимс, жимсгэнэ                   | 30.0            | 34.7       | 20.3       |
| Буурцагт ургамал                 | 0.1             | 0.2        | 0.0        |
| Өндөг                            | 9.3             | 12.8       | 2.0        |
| Ургамлын тос                     | 16.5            | 13.2       | 20.5       |
| <b>Цөцгийн тос, масло</b>        | <b>7.0</b>      | <b>9.6</b> | <b>3.8</b> |

Эх үүсвэр: ӨНЭЗС, УСХ

ӨНЭЗС-аар жишсэн нэг хүний хүнсний бодит хэрэглээ зуны улиралд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, ургамлын тосыг улсын дунджаас давж хэрэглэдэг бол хотод гурилан бүтээгдэхүүн, саахар, чихрийн зүйл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг, цөцгийн тосыг улсын дунджаас давж хэрэглэдэг гэсэн үр дүн гарсан байна.

**Хүснэгт 8. ЖИШСЭН НЭГ ХҮНД ХОНОГТ НОГДОХ ХҮНСНИЙ  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛСЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ, ЗУНЫ УЛИРАЛД, ХОТ,  
ХӨДӨӨГӨӨР, 2017 ОН**

| Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл | Улсын<br>дундаж | Хот        | Хөдөө      |
|----------------------------------|-----------------|------------|------------|
|                                  | грамм           |            |            |
| Маж, махан бүтээгдэхүүн          | 312.9           | 255.3      | 437.2      |
| Сүү                              | 188.7           | 146.2      | 280.4      |
| Сүүн бүтээгдэхүүн                | 237.1           | 126.6      | 475.6      |
| Гурил                            | 177.9           | 120.7      | 301.2      |
| Гурилан бүтээгдэхүүн             | 181.5           | 208.9      | 122.4      |
| Төрөл бүрийн будаа               | 63.4            | 58.7       | 73.7       |
| Саахар, чихрийн зүйл             | 61.4            | 68.5       | 46.1       |
| Төмс                             | 94.8            | 99.7       | 84.1       |
| Хүнсний ногоо                    | 74.5            | 84.6       | 52.8       |
| Жимс, жимсгэнэ                   | 39.1            | 44.2       | 28.2       |
| Буурцагт ургамал                 | 0.2             | 0.2        | 0.0        |
| Өндөг                            | 10.3            | 14.0       | 2.3        |
| Ургамлын тос                     | 17.5            | 14.3       | 21.5       |
| <b>Цөцгийн тос, масло</b>        | <b>6.2</b>      | <b>9.0</b> | <b>2.6</b> |

Эх үүсвэр: ӨНЭЗС, ҮСХ

**2. Хүнсний хүртээмж, өрхийн түвшинд**

Маж, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, саахар, чихрийн зүйлийн хүртээмж хангалттай, бусад хүнсний бүтээгдэхүүний хүртээмж хангалтгүй буюу дутагдалтай байна. Хүн амын хүнсний хэрэгцээ нь үндсэндээ мах, махан бүтээгдэхүүн, сүү, гурил зонхилон хангагдсан хэвээр байна.

### Хүснэгт 8. ХҮНСНИЙ ХҮРТЭЭМЖ, ХУВИАР, 2017 он

| Хүнсний<br>бүтээгдэхүүний нэр<br>төрөл | Жишсэн<br>нэг хүний<br>хоногийн<br>хүнсний<br>хэрэгцээ | Улсын дундаж<br>хэрэглээ |                     | Хүртээмж        |                     |
|----------------------------------------|--------------------------------------------------------|--------------------------|---------------------|-----------------|---------------------|
|                                        |                                                        | Зуны<br>улиралд          | Сэрүүний<br>улиралд | Зуны<br>улиралд | Сэрүүний<br>улиралд |
|                                        | грамм                                                  |                          |                     | хувь            |                     |
| Мах, махан                             | 190.0                                                  | 312.9                    | 307.2               | 164.7           | 161.7               |
| бүтээгдэхүүн                           |                                                        |                          |                     |                 |                     |
| Сүү                                    | 160.0                                                  | 188.7                    | 161.8               | 117.9           | 101.1               |
| Сүүн бүтээгдэхүүн                      | 180.0                                                  | 237.1                    | 204.6               | 131.7           | 113.7               |
| Гурил                                  | 100.0                                                  | 177.9                    | 181.0               | 177.9           | 181.0               |
| Гурилан бүтээгдэхүүн                   | 180.0                                                  | 181.5                    | 170.6               | 100.8           | 94.8                |
| Төрөл бүрийн будаа                     | 50.0                                                   | 63.4                     | 61.1                | 126.8           | 122.2               |
| Саахар, чихрийн зүйл                   | 33.0                                                   | 61.4                     | 51.9                | 186.1           | 157.3               |
| Төмс                                   | 120.0                                                  | 94.8                     | 94.8                | 79.0            | 79.0                |
| Хүнсний ногоо                          | 260.0                                                  | 74.5                     | 74.4                | 28.7            | 28.6                |
| Жимс, жимсгэнэ                         | 200.0                                                  | 39.1                     | 30.0                | 19.6            | 15.0                |
| Буурцагт ургамал                       | 40.0                                                   | 0.2                      | 0.1                 | 0.5             | 0.3                 |
| Өндөг                                  | 20.0                                                   | 10.3                     | 9.3                 | 51.5            | 46.5                |
| Ургамлын тос                           | 23.0                                                   | 17.5                     | 16.5                | 76.1            | 71.4                |
| Цөцгийн тос                            | 10.0                                                   | 6.2                      | 7.0                 | 62.0            | 70.0                |

Эх үүсвэр: ӨНЭЗС, ҮСХ

### ГУРАВ. ХҮНСНИЙ ИЛЧЛЭГ ШИМ ТЭЖЭЭЛ

Жишсэн нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний илчлэг, найрлагыг улсын дундаж, хот, хөдөөгөөр, сэрүүн, зуны улирлаар ангилж гаргалаа.

#### 1. Зуны улиралд

Улсын дунджаар жишсэн нэг хүний зуны улиралд хүнсний бүтээгдэхүүнээс авсан илчлэг 3065.9 киллкалори, уураг 136.1 грамм, тос 70.4 грамм, нүүрс ус 474.1 грамм байгаа нь жишсэн нэг хүний хүнснээс авах илчлэгийн нормтой харьцуулахад 5.1-51.2 хувиар өндөр байна.

**Хүснэгт 9. ЖИШСЭН НЭГ ХҮНИЙ ХҮНСНЭЭС АВАХ ИЛЧЛЭГ, ШИМ  
ТЭЖЭЭЛ, УЛСЫН ДУНДАЖ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ЗУНЫ УЛИРАЛД**

|                       | Жишсэн<br>нэг хүний<br>хүнснээс<br>авах<br>илчлэгийн<br>норм | Улсын дундаж |         | Хот     |         | Хөдөө   |         |
|-----------------------|--------------------------------------------------------------|--------------|---------|---------|---------|---------|---------|
|                       |                                                              | 2016         | 2017    | 2016    | 2017    | 2016    | 2017    |
| Илчлэг,<br>киллкалори | 2400                                                         | 2 709.2      | 3 065.9 | 2 397.1 | 2 777.5 | 3 372.5 | 3 684.3 |
| Уураг, грамм          | 90                                                           | 117.8        | 136.1   | 99      | 114.1   | 157.9   | 183.6   |
| Тос, грамм            | 67                                                           | 84.2         | 70.4    | 69.8    | 53.9    | 114.9   | 105.4   |
| Нүүрс ус,<br>грамм    | 360                                                          | 366.9        | 474.1   | 339.9   | 459.8   | 424.2   | 505.1   |

Эх үүсвэр: ӨНЭЗС, ҮСХ

Судалгааны үр дүнгээр, бодитойгоор гарсан жишсэн нэг хүний хоногт хүнснээс авсан илчлэг, шим тэжээлийн хэмжээ нь жишсэн нэг хүний хоногт хүнснээс авах ёстой илчлэг, шим тэжээлийн нормоос давсан байгаа нь харагдаж байна.

Харин жишсэн хүний хоногт хүнснээс авах илчлэг, шим тэжээлийн хэмжээ хот, хөдөөд харилцан адилгүй байна. Хотын хүн амын хүнснээс авах илчлэг, уураг, тосны хэмжээ физиологийн түвшнээс бага, хөдөөд хүнснээс авах илчлэг, уураг, тос, нүүрс усны илчлэг нормоос давсан байна.

## **2. Сэрүүний улиралд**

Улсын дунджаар жишсэн нэг хүний сэрүүний улиралд хүнсний бүтээгдэхүүнээс авсан илчлэг 3098.6 киллкалори уураг 136.1 грамм, тос 70.1 грамм, нүүрс ус 452.7 грамм байгаа нь жишсэн нэг хүний хүнснээс авах нормтой харьцуулахад нүүрс ус, илчлэг, уураг, тосны хэмжээ нормоос 4.6-51.2 хувиар их байна.

**Хүснэгт 10. ЖИШСЭН НЭГ ХҮНИЙ ХҮНСНЭЭС АВАХ ИЛЧЛЭГ, ШИМ  
ТЭЖЭЭЛ, УЛСЫН ДУНДАЖ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, СЭРҮҮНИЙ УЛИРАЛД**

|                       | Хүнснээс<br>авах<br>илчлэгийн<br>норм | Улсын дундаж |         | Хот     |         | Хөдөө   |         |
|-----------------------|---------------------------------------|--------------|---------|---------|---------|---------|---------|
|                       |                                       | 2016         | 2017    | 2016    | 2017    | 2016    | 2017    |
| Илчлэг,<br>киллкалори | 2 400.0                               | 2 599.8      | 3 098.6 | 2 399.1 | 2 978.0 | 3 012.9 | 3 346.8 |
| Уураг, грамм          | 90.0                                  | 115.9        | 136.1   | 103.8   | 123.3   | 140.8   | 162.4   |
| Тос, грамм            | 67.0                                  | 81.2         | 70.1    | 71.8    | 60.1    | 100.5   | 90.2    |
| Нүүрс ус, грамм       | 360.0                                 | 348.5        | 452.7   | 331.1   | 448.0   | 384.2   | 462.5   |

Эх үүсвэр: ӨНЭЗС, ҮСХ

Сэрүүний улиралд хүн амын хүнснээс авах илчлэг, уураг, нүүрс усны хэмжээ их, хотод тосны хэмжээ физиологийн нормын түвшнээс бага, хөдөөд илчлэг, уураг, тос, нүүрс усны хэмжээ нормоос давсан байна.

## **ДӨРӨВ. ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

### **1. Хяналт шалгалтаар, итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторын шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин**

2017 онд 13.6 мянган бүтээгдэхүүнд нянгийн бохирдолтын шинжилгээ хийхэд 0.3 мянга буюу 2.4 хувь, 9.6 мянган бүтээгдэхүүнд химийн бохирдолтын шинжилгээ хийхэд 0.4 мянга буюу 4.0 хувь нь бохирдолтой гэсэн дүн гарчээ.

### **2. Хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүн**

МХЕГ-ын хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан бүтээгдэхүүнийг дараах хүснэгтээр харуулав.

#### **Хүснэгт 11. ХЯНАЛТ, ШАЛГАЛТААР ХУРААСАН, БУЦААСАН, ТАТАН АВСАН, УСТГАСАН ДОТООДЫН ҮЙЛДВЭРИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН**

| Үзүүлэлт                 | Хэмжих нэгж | 2015    | 2016    | 2017    |
|--------------------------|-------------|---------|---------|---------|
| Хураасан бүтээгдэхүүн    | киллограмм  | 3 766.8 | 654.9   | 5572.5  |
|                          | литр        | 2 911.0 | 544.5   | 1574.0  |
|                          | ширхэг      | 19 537  | 82 670  | 42010   |
| Буцаасан бүтээгдэхүүн    | киллограмм  | 1 511.0 | 313.5   | 781.7   |
|                          | литр        | -       | 115.0   | 214.0   |
|                          | ширхэг      | 46 250  | 5 391   | 12573.0 |
| Татан авсан бүтээгдэхүүн | киллограмм  | 462.0   | 238.3   | 611.7   |
|                          | литр        | 336.0   | 6.4     | 64.0    |
|                          | ширхэг      | 3 248   | 12 869  | 6030    |
| Устгасан бүтээгдэхүүн    | киллограмм  | 4 088.9 | 2 229.7 | 8396.6  |
|                          | литр        | 1 586.0 | 648.5   | 1546.1  |
|                          | ширхэг      | 18 527  | 82 530  | 39552   |

Эх үүсвэр: МХЕГ

### **3. Хяналтад хамрагдсан, үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн ААНБ, иргэдийн тоо**

МХЕГ-аас явуулсан хяналт, шалгалтад нийт 5290 ААНБ, 4850 иргэд хамрагдаж, зөрчил гаргасан 81 ААНБ, 49 иргэдийн үйл ажиллагааг зогсоож, 45 ААНБ, 19 иргэдийн үйл ажиллагааг сэргээсэн байна.

**Хүснэгт 12. ХЯНАЛТАД ХАМРАГДСАН, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООСОН,  
СЭРГЭЭСЭН ААНБ, ИРГЭДИЙН ТОО**

| Үзүүлэлт                     | 2015  |        | 2016  |       | 2017 |       |
|------------------------------|-------|--------|-------|-------|------|-------|
|                              | ААНБ  | Иргэд  | ААНБ  | Иргэд | ААНБ | Иргэд |
| Хяналтад хамрагдсан          | 6 897 | 24 950 | 4 785 | 3 072 | 5290 | 4850  |
| Үйл ажиллагааг түр зогсоосон | 68    | 66     | 119   | 44    | 81   | 49    |
| Үйл ажиллагааг сэргээсэн     | 49    | 32     | 58    | 30    | 45   | 19    |

*Эх үүсвэр: МХЕГ*

**Хяналт, шалгалтын явцад илрүүлсэн болон арилгуулсан зөрчил**

МХЕГ-аас явуулсан хяналт, шалгалтаар нийт 28.3 мянган зөрчил илрүүлснээс 70.4 хувь буюу 19.9 мянган зөрчлийг арилгуулсан байна.

**Хүснэгт 13. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН БОЛОН  
АРИЛГУУЛСАН ЗӨРЧИЛ**

| Үзүүлэлт                                                  | Илрүүлсэн<br>зөрчлийн<br>тоо | Арилгуулсан<br>зөрчлийн тоо |
|-----------------------------------------------------------|------------------------------|-----------------------------|
|                                                           |                              |                             |
| Бүгд                                                      | 28278                        | 19904                       |
| Барилга, байгууламжийн норм дүрмийн                       | 3256                         | 1632                        |
| Ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн             | 2895                         | 2167                        |
| Технологийн үйл ажиллагааны                               | 2836                         | 2048                        |
| Ариун цэвэр, эрүүл ахуйн                                  | 5436                         | 4177                        |
| Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй<br>байдлын | 3118                         | 2318                        |
| Хадгалалт, тээвэрлэлтийн                                  | 3576                         | 2429                        |
| Сав, баглаа, боодол, хаяг, шошгын                         | 3039                         | 2372                        |
| Дотоодын хяналтын                                         | 3872                         | 2761                        |

*Эх үүсвэр: МХЕГ*

Илрүүлсэн зөрчлийн 19.4 хувийг ариун цэвэр, эрүүл ахуйн, 13.7 хувийг дотоодын хяналтын, 12.8 хувийг хадгалалт, тээвэрлэлтийн, 11.7 хувийг барилга, байгууламжийн норм дүрмийн, 11.2 хувийг түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын, 10.9 хувийг сав, баглаа, боодол, хаяг, шошгын, 10.3 хувийг ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн, 10.1 хувийг технологийн үйл ажиллагааны зөрчил эзэлж байна. Харин эдгээр зөрчил тус бүрийн 49.4-76.9 хувийг арилгуулжээ.

**4. Хүнсний бүтээгдэхүүнд сорилт, шинжилгээ хийх эрх бүхий итгэмжлэгдсэн лабораторын тоо:**

Хүнсний бүтээгдэхүүнд сорилт, шинжилгээ хийх эрх бүхий итгэмжлэгдсэн 91 лаборатор 2017 онд үйл ажиллагаа явуулж байна.

## **5. Хүнсний холбогдолтой үндэсний, олон улс, бүс нутаг, гадаад орны стандарт болон техникийн зохицуулалт**

Монгол улсын хэмжээнд 2017 оны байдлаар хүнсний салбарт дараах техникийн зохицуулалтыг мөрдөж байна. Үүнд:

1. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт, МУЗГ-ын 2008 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 159 дүгээр тогтоол;
2. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, худалдааны техникийн зохицуулалт, МУЗГ-ын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 304 дүгээр тогтоол;
3. Бялууны төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохицуулалт, МУЗГ-ын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 305 дүгээр тогтоол.

### **Хүснэгт 14. ХҮНСНИЙ ХОЛБОГДОЛТОЙ ҮНДЭСНИЙ СТАНДАРТЫН ТОО**

| <b>Үзүүлэлт</b>                                                               | <b>2015</b> | <b>2016</b> | <b>2017</b> |
|-------------------------------------------------------------------------------|-------------|-------------|-------------|
| Нийт стандартын тоо                                                           | 652         | 600         | 652         |
| Олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн стандарт | 249         | 240         | 240         |
| Уялдуулсан стандарт                                                           | 403         | 360         | 412         |

Эх үүсвэр: СХЗГ

Үндэсний 652 стандарт мөрдөж байгаагаас 240 буюу 36.8 хувь нь олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн, 412 буюу 63.2 хувь нь уялдуулсан стандарт байна.

## **6. Тохирлын үнэлгээнд хамрагдсан ААНБ, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл**

Хүнсний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 175 ААНБ тохирлын үнэлгээнд хамрагдсан байна. Энэ нь өмнөх онынхоос 10 ААНБ буюу 6.1 хувиар өссөн байна.

**Хүснэгт 15. ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН ААНБ, ХҮНСНИЙ  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ**

| Үзүүлэлт                                                 | 2015               |                              | 2016               |                              | 2017               |                              |
|----------------------------------------------------------|--------------------|------------------------------|--------------------|------------------------------|--------------------|------------------------------|
|                                                          | ААНБ<br>-ын<br>тоо | Бүтээгдэ<br>-хүүний<br>төрөл | ААНБ<br>-ын<br>тоо | Бүтээгдэ<br>-хүүний<br>төрөл | ААНБ<br>-ын<br>тоо | Бүтээгдэ<br>-хүүний<br>төрөл |
| <b>Бүгд</b>                                              | <b>302</b>         | <b>215</b>                   | <b>165</b>         | <b>755</b>                   | <b>175</b>         | <b>621</b>                   |
| Импортын бүтээгдэхүүний<br>баталгаажуулалт               | 86                 | 36                           | 115                | 335                          | 97                 | 301                          |
| Дотоодын үйлдвэрийн<br>бүтээгдэхүүний<br>баталгаажуулалт | 207                | 165                          | 42                 | 400                          | 79                 | 354                          |
| “Үндэсний тохирлын<br>тэмдэг”-ийн баталгаажуулалт        | 9                  | 14                           | 8                  | 20                           | 7                  | 48                           |

Эх үүсвэр: СХЗГ

Тохирлын үнэлгээнд хамрагдаж баталгаажуулалт хийгдсэн нийт 621 төрлийн бүтээгдэхүүн байна. Үүний 48.5 хувьд нь импортын бүтээгдэхүүний баталгаажуулалт, 57.0 хувьд нь дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний баталгаажуулалт, 7.7 хувьд нь “Үндэсний тохирлын тэмдэг”-ийн баталгаажуулалт хийгджээ.

**7. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн үйлдвэрийн тоо**

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаас байгууллагын чанарын удирдлагын тогтолцоонд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн гэрчилгээ олгогдсон буюу Чанарын удирдлагын тогтолцоо **MNS ISO 9001:2010** стандартыг нэвтрүүлсэн хүнсний салбарын 12 ААНБ байна.

**8. Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэрийн тоо**

Эрх бүхий байгууллагаас зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж, гэрчилгээ олгосон хүнсний салбарын 7 ААНБ байна.

**Хүснэгт 16. ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ЗОХИСТОЙ ДАДАЛ, АЮУЛЫН ДҮН  
ШИНЖИЛГЭЭ БА ЭГЗЭГТЭЙ ЦЭГИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ  
НЭВТРҮҮЛСЭН ҮЙЛДВЭРИЙН ТОО**

| Үзүүлэлт                                                                          | 2015 | 2016 | 2017 |
|-----------------------------------------------------------------------------------|------|------|------|
| Нийт үйлдвэрийн тоо                                                               | 4    | 5    | 7    |
| Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны<br>ISO22000 стандартыг нэвтрүүлсэн | 3    | 3    | 3    |
| ЭЦАБШХТ /НАССР/ нэвтрүүлсэн                                                       | 1    | 2    | 4    |

Эх үүсвэр: СХЗГ



### **9. Баяжуулсан хүнс үйлдвэрлэдэг үйлдвэрийн тоо, үйл ажиллагааны төрлөөр**

Иоджуулсан давсны 5 үйлдвэр жилд 30.0 мянган тонн давс боловсруулж, савлах үйл ажиллагаа явуулж байна.

### **10. Баталгаат ундны усаар хангагдаж буй хүн амын тоо**

Хүн ам, орон сууцны тооллогын 2010 оны дүнгээр Монгол Улсын нийт хүн амын 72.6 хувь буюу 1922.2 мянган хүн баталгаат ундны усаар хангагдаж байна.

### **12. Архи, дарс, шар айраг, спиртийн үйлдвэрийн тоо**

Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй спиртийн 9, архины 45, дарсны 10, шар айрагны 19 үйлдвэр байна.

### **13. Нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээ**

2017 оны байдлаар нэг хүнд 8.2 литр архи, 0.9 литр дарс, 27.9 литр шар айраг ногдож байна.

#### **Хүснэгт 17. НЭГ ХҮНД НОГДОХ АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭМЖЭЭ**

|           | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|-----------|------|------|------|------|
|           | литр |      |      |      |
| Архи      | 8.3  | 7.1  | 8.0  | 8.2  |
| Дарс      | 0.9  | 0.7  | 0.7  | 0.9  |
| Шар айраг | 29.8 | 29.7 | 29.6 | 27.9 |

Эх үүсвэр: ҮСХ

2017 оны байдлаар 15 ба түүнээс дээш насны нэг хүнд 11.7 литр архи, 1.2 литр дарс, 40.2 литр шар айраг ногдож байна.

#### **Хүснэгт 18. 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ НЭГ ХҮНД НОГДОХ АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭМЖЭЭ**

|           | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|-----------|------|------|------|------|
|           | литр |      |      |      |
| Архи      | 11.9 | 10.1 | 11.4 | 11.7 |
| Дарс      | 1.2  | 1.1  | 0.9  | 1.2  |
| Шар айраг | 42.4 | 42.1 | 42.3 | 40.2 |

Эх үүсвэр: ҮСХ

### **14. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт болон өвчилсөн хүний тоо, үүнээс эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, нас барсан хүний тоо**

Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт гэж ижил төрлийн хоол хүнс хэрэглэснээс үүдэн нэг өвчний **хоёр** ба түүнээс олон тохиолдол илрэхийг хэлнэ.

2017 онд хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт 5 удаа бүртгэгдэж 118 хүн өвчилсний 98 буюу 83.1 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, хүний амь нас эрсдээгүй байна.

**Хүснэгт 19. ХООЛ ХҮНСЭЭР ДАМЖИХ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТ,  
ӨВЧИЛСӨН, ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ЭМЧЛҮҮЛСЭН БОЛОН НАС БАРСАН  
ХҮНИЙ ТОО**

| Үзүүлэлт                                  | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|-------------------------------------------|------|------|------|------|
| Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн тоо | 11   | 6    | 12   | 5    |
| Өвчилсөн хүний тоо                        | 766  | 311  | 382  | 118  |
| Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн                | 244  | 33   | 127  | 98   |
| Амь насаа алдсан хүний тоо                | -    | -    | -    | -    |

Эх үүсвэр: ЭМЯ

2014-2017 оны байдлаас харахад 2014 онд хоол хүнсээр дамжих өвчин 11 удаа гарч 766 хүн өвчилсөн нь тухайн онд өвчний дэгдэлт их байсныг харуулж байна.

**Хүснэгт 20. НЯНГИЙН ГАРАЛТАЙ ХООЛ ХҮНСНЭЭС ШАЛТГААЛСАН  
ХОРДЛОГОТ ХАЛДВАРТ ӨВЧЛӨЛ**

| Үзүүлэлт           | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|--------------------|------|------|------|------|
| Өвчилсөн хүний тоо | 548  | 482  | 430  | 133  |
| Хот                | 235  | 375  | 386  | 89   |
| Хөдөө              | 313  | 107  | 44   | 44   |

Эх үүсвэр: ЭМЯ

## **ЗУРГАА. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН САН**

Хүнсний аюулгүй байдалд дохио өгч, шалгуур тогтооход шаардлагатай үндсэн болон бусад үзүүлэлтүүдээр хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийн мэдээллийн санг дараах үзүүлэлтүүдээр 2007-2017 оны байдлаар бий болгоод байна. Үүнд:

### **6.1. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үндсэн үзүүлэлтүүд**

6.1.1 Хүнсний хангамж, хүртээмжийн үзүүлэлт

6.1.2 Хүнсний илчлэг, шим тэжээлийн үзүүлэлт

6.1.3 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлт

- Хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин: Хүнсний бүтээгдэхүүний нянгийн болон химийн бохирдолтын түвшин
- Буцаасан, хураасан, устгасан импортын бүтээгдэхүүний тоо хэмжээ
- Хураасан, устгасан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ
- Хяналт, шалгалтад хамрагдсан ААНБ, хувь хүний тоо
- Хяналт, шалгалтаар үйл ажиллагааг нь бүр зогсоосон, түр зогсоосон, үйл ажиллагааг нь сэргээсэн байгууллага, иргэний тоо
- Хяналт, шалгалтын явцад илрүүлсэн, арилгуулсан зөрчил: Дотоодын хүнсний үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын түвшин
- Импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлага хангалтын түвшин
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн байдал
- Улсын хэмжээнд итгэмжлэгдсэн лабораторийн тоо
- Монгол улсын хэмжээнд хүнсний салбарт мөрдөгдөж байгаа Үндэсний MNS, CAC, гадаад орны стандартын тоо,
- Олон улс, бүс нутаг, гадаад орны стандартыг Үндэсний стандарт болгосон стандартын тоо
- Тохирлын үнэлгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн тоо
- Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаас баталгаажуулалт авсан үйлдвэрийн тоо
- Үйл ажиллагаандаа зохистой дадал, хяналт болон удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэрийн тоо
- Баяжуулсан хүнсний хувийн жин, бүтээгдэхүүний төрлөөр
- Баяжуулсан хүнс бэлтгэдэг үйлдвэрийн тоо, үйл ажиллагааны төрлөөр
- Баталгаат ундны усаар хангагдаж буй хүн амын тоо
- Архи, шар айраг, спиртийн үйлдвэрийн тоо
- 10000 хүн амд тутамд ногдох согтууруулах ундаа зарж, борлуулах зөвшөөрөлтэй цэгийн тоо

- Нэг хүнд ногдох архи, шар айраг, спиртын бүтээгдэхүүн, насанд хүрэгчид, нийт хүн амд ногдуулж бодсноор
- Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн тоо, өвчилсөн хүний тоо, үүнээс эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, амь насаа алдсан хүний тоо

#### 6.1.4 Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг цэг

- Хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо, төрлөөр
- Хүнсний дэлгүүр, супермаркетын тоо
- Хүнсний захын тоо
- Хүнсний агуулах, зоорийн тоо, хүчин чадал, бүтээгдэхүүний төрлөөр
- Цайны газар, гуанз, зоогийн газрын тоо
- Цэвэр ус, ундаа, архи, пиво, спиртийн үйлдвэрийн тоо
- 10000 хүн амд тутамд ногдох согтууруулах ундаа зарж, борлуулах зөвшөөрөлтэй цэгийн тоо

#### 6.1.5 Хүнстэй холбоотой эрүүл мэндийн мэдээлэл

- Хоол хүнсээр дамжих өвчнөөр өвчилсөн хүний тоо, хот, хөдөөгөөр
- Хоол, хүнстэй холбоотой бусад өвчлөлийн мэдээлэл
- Байх ёстой жингээс доогуур жинтэй 5 ба түүнээс доош насны хүүхдийн тоо, хүйсээр, хот, хөдөөгөөр
- Нянгийн гаралтай хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдварын өвчлөлөөр өвчилсөн хүний тоо, хот, хөдөөгөөр
- Химийн гаралтай хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдварын өвчлөлөөр өвчилсөн хүний тоо, хот, хөдөөгөөр
- Хоол, хүнсээр дамжих өвчний улмаас хордлого, халдварын өвчлөлөөр өвдөж, амь насаа алдсан хүний тоо, хот, хөдөөгөөр

### 6.2. Хүнсний аюулгүй байдлыг тодорхойлох бусад үзүүлэлтүүд

#### 6.2.1 Хөдөө аж ахуй

- Малын тоо, төрлөөр
- Хээлтэгч малын тоо, төрлөөр
- Хүнсэнд хэрэглэсэн малын тоо, төрлөөр
- Мах үйлдвэрлэл
- Сүү үйлдвэрлэл
- ХАА-н эдэлбэр газрын хэмжээ, га-гаар
- Тариалсан талбай, ургамлын төрлөөр
- Хураасан талбай, ургамлын төрлөөр
- Хураасан ургац, ургамлын төрлөөр
- Га-гийн ургац, ургамлын төрлөөр
- Жишсэн хүн амын гурилын хэрэгцээ, үүнийг хангахад шаардлагатай үр тариа, тариалсан талбайн хэмжээ, тооцоогоор

#### 6.2.2 ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл

- Мал аж ахуй
- Газар тариалан

#### 6.2.3 ХАА-н нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь

- Мал аж ахуй
- Газар тариалан

#### 6.2.4 Аж үйлдвэр

- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, биет хэмжээгээр
- Архи, шар айраг, спиртийн үйлдвэрлэл, биет хэмжээгээр
- Нэг хүнд ногдох архи, шар айраг, спиртэн бүтээгдэхүүн, биет хэмжээгээр, нийт хүн ам, насанд хүрэгчдэд ногдуулснаар
- Ундны усны үйлдвэрлэл, биет хэмжээгээр

#### 6.2.5 Гадаад худалдаа

- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импорт, биет хэмжээгээр, улс, орноор
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний экспорт, биет хэмжээгээр, улс, орноор
- Савласан ундны усны импорт, биет хэмжээгээр, улс, орноор

#### 6.2.6 Үнэ

- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импортын үнэ
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний экспортын үнэ
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн үнэ
- Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний бөөний үнийн мэдээ

#### 6.2.7 Хүн амын тоо

- Суурин хүн амын тоо, нас, хүйсээр

#### 6.2.8 Ажиллагчдын тоо

- Ажиллагчдын тоо, салбараар
- Мал аж ахуйд ажиллагчдын тоо
- Газар тариаланд ажиллагчдын тоо
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоо

#### 6.2.9 Ундны ус

- Ундны ус түгээх цэгийн тоо
- Ус тээврийн автомашины тоо
- Баталгаат усан хангамжаар хангагдсан хүн амын тоо
- Төвлөрсөн усан хангамжийн нян, химийн бохирдолтын түвшин
- Төвлөрсөн бус усан хангамжийн нян, химийн бохирдолтын түвшин

- 6.2.10 Үйлдвэрлэлийн мэдээ, үйлдвэрлэлийн төрлөөр, гол нэрийн бүтээгдэхүүний нэр төрлөөр
- Үйлдвэрийн тоо
  - Үйлдвэрлэлийн тоо хэмжээ
  - Үйлдвэрлэлийн хүчин чадал / ашиглалт
  - Зохистой дадал нэвтрүүлсэн байдал
  - Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдал
- 6.2.11 Савласан ус, согтууруулах ба согтруулах бус ундааны үйлдвэрлэл, гол нэрийн бүтээгдэхүүний нэр төрлөөр
- Үйлдвэрийн тоо
  - Үйлдвэрлэлийн тоо хэмжээ
  - Үйлдвэрлэлийн хүчин чадал / ашиглалт
  - Зохистой дадал нэвтрүүлсэн байдал
  - Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдал
- 6.2.12 Хүнсний худалдаа эрхлэлтийн байдал, төрлөөр
- Тоо хэмжээ
  - Үндсэн хүчин чадал
  - Ашиглагдаж буй хүчин чадал
  - Зохистой дадал нэвтрүүлсэн байдал
  - Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдал
- 6.2.13 Гол нэр төрлийн хүнсний 13 бүтээгдэхүүн болон савласан усны гадаад худалдааны мэдээ, гаалийн бүрдүүлэлт хийсэн газар, хороодоор
- Тоо хэмжээ
  - Үнийн дүнгээр, ам доллараар
- 6.2.14 Ундаа, согтууруулах ундааны гадаад худалдааны мэдээ, гаалийн бүрдүүлэлт хийсэн газар, хороодоор:
- Тоо хэмжээ
  - Үнийн дүнгээр, ам доллараар
- 6.2.15 Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний гадаад худалдаа, тээвэрлэлтийн төрлөөр, нэр төрлөөр
- Тоо хэмжээ
  - Үнийн дүнгээр, ам доллараар
- 6.2.16 Гол нэр төрлийн хүнсний 13 бүтээгдэхүүн болон савласан усны гадаад худалдааны үеийн хүнсний бүтээгдэхүүний хадгалалт
- Тоо хэмжээ
  - Үнийн дүнгээр, ам доллараар
- 6.2.17 Нийтийн хоолны үйлдвэрлэл, төрлөөр
- Тоо хэмжээ
  - Үндсэн хүчин чадал
  - Ашиглагдаж буй хүчин чадал
  - Зохистой дадал нэвтрүүлсэн байдал
  - Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдал

6.2.18 Хүнсний тусламжийн талаарх мэдээ, хандивлагч улсаар, бараагаар:

- Хүнсний нэр төрөл
- Хандивлагч улсын нэр
- Тоо хэмжээ
- Үнийн дүнгээр, ам доллараар

**Хүснэгт 1. Жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүр**

| Насны бүлэг              | Хүйс   | Мөрийн дугаар | Шилжүүлэх итгэлцүүр |
|--------------------------|--------|---------------|---------------------|
| А                        | Б      | В             | 1                   |
| 1 хүртэлх насны          | эм, эр | 1             | 0.38                |
| 1-3 насны                | эм     | 3             | 0.48                |
|                          | эр     | 4             | 0.50                |
